

Эрүүл мэндийг дэмжигч:



2019 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Certified **SGS**

АГУУЛГА:

- Гүйцэтгэх захирлын захидал
- Компанийн танилцуулга
- Бүтээгдэхүүний нэр төрлүүд
- III улирлын онцлох үйл явдлууд
- Санхүүгийн тайлан
- Хувьцааны ханшийн мэдээлэл
- Компанийн засаглал



“ЭРҮҮЛ МЭНДИЙН УС УНДААНЫ ҮЙЛДВЭРЭЭ 2019 ОНДОО БАГТААН АШИГЛАЛТАД ОРУУЛНА”

Бидэнд итгэл хүлээлгэн хөрөнгө оруулсан нийт хувьцаа эзэмшигчиддээ дахин талархсанаа илэрхийлье.

Монос Хүнс ХК нь эх орны хөрсөнд ургасан биологийн идэвхит түүхий эдийг ашиглан, эрдэмтэн судлаачдын олон жилийн туршилт, судалгааны үр дүнд зохион бүтээсэн эрүүл мэндийн хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг Монголдоо бахархалтайгаар үйлдвэрлэсээр ирсэн.

Эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүнийг иргэдийн өдөр тутмын хэрэглээ болгохын тулд, бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дамжуулж хэрэглэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох нь зайлшгүй бөгөөд үүний төлөө манай хамт олон хичээнгүйлэн хөдөлмөрлөсөөр байна.

Өнгөрч буй 3 дугаар улирал бидний хувьд амжилт бүтээл ажлын ачааллын хувьд өндөр сарууд байлаа. Шинэ үйлдвэрийн угсралтын

ажлуудын хажуугаар 2017 оны сүүлээс хэрэгжүүлж эхэлсэн Олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, Хүнсний Аюулгүй Байдлын HACCP стандартуудаа Женев хотод төвтэй SGS байгууллагаар баталгаажуулж чадлаа. Ингэснээр бидний үйл ажиллагаа Олон улсад албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөж Экспортын борлуулалтаа нэмэгдүүлэх таатай боломж нээгдэж байгаа юм.

Шинээр ашиглалтад орох “Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр”-ийн ажлууд тодорхой хэмжээнд хойшилсон хэдий ч одоогоор 90 орчим хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Үйлдвэрээ бид энэ ондоо багтаан бүрэн ашиглалтад оруулахаар зорин ажиллаж байгаа бөгөөд эхний ээлжинд нийт 15 нэр төрлийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд танилцуулах юм.

**Хүндэтгэсэн
Гүйцэтгэх захирал А.Отгондарь**





Монос Хүнс ХК нь 2012 оноос хойш ард иргэдийнхээ эрүүл мэндийг дэмжих зорилготойгоор хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Монгол орны хөрсөнд ургасан, байгалийн гаралтай түүхий эдийг биологийн идэвх хамгийн өндөртэй үед сорчлон түүж, бэлтгэн эрүүл мэндийг дэмжих үйлдэлтэй хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл мэндийг дэмжсэн хүнсний бүтээгдэхүүнийг, хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэн, олон улсын стандартаар **ҮЙЛДВЭРЛЭГЧ**, **ЭКСПОРТЛОГЧ**, дотоодын зах зээлд **ТЭРГҮҮЛЭГЧ** компани байна.



АЛСЫН ХАРАА

Эрүүл мэндийг дэмжсэн **ОРГАНИК** хүнсний бүтээгдэхүүнийг өдөр тутмын хэрэглээнд хэвшүүлэх.



ҮНЭТ ЗҮЙЛС

- Эрхэм хэрэглэгч
- Эрүүл, чанартай бүтээгдэхүүн
- Итгэлтэй харилцагч
- Ёс зүйтэй бизнес
- Мэдлэг, чадвартай бүтээлч хамт олон
- Шинэ санал, санаачилга

Цэнэг эрүүл мэндийн бэлдмэл



Эко уусдаг цай



Гоолингоо
тураах цай



100 наслаарай
Монгол цай



Энхжин эрүүл мэндийн цай



Ааруултай үрэл



Үзэмтэй үрэл



Аами Таами үрэл



Витаминт үрэл



Чацаргана жимсний тос болон шүүс



Экос зөөлөн ус



Өтгөрүүлсэн барагшун



Шидэт хар саримс



Барагшун +С витаминт үрэл





МОНОС ХҮНС ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ОЛОН УЛСАД ИТГЭМЖЛЭГДЛЭЭ

Монос Хүнс ХК нь Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлээ.

Монос Хүнс ХК нь хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг дээшлүүлэх, эрүүл, аюулгүй, чанартай бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн гарт хүргэх зорилгоор 2018 оноос эхлэн Олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо /ISO 9001:2015/, Хүнсний аюулгүй байдлын /HACCP/ стандартуудыг нэвтрүүлж эхэлсэн.

Эдгээр стандартуудын хэрэгжүүлэлтийг шалган баталгаажуулахаар Швейцар улсад төвтэй SGS

компанийн аудит 2 үе шаттайгаар явагдсан бөгөөд, сүүлийн шатны хяналт өнгөрөгч 09 дүгээр сард болж өнгөрсөн юм. Ийнхүү Монос Хүнс ХК-ийг ISO 9001:2015, HACCP стандартыг амжилттайгаар нэвтрүүлснийг баталгаажууллаа.

Ингэснээр Монос Хүнс ХК-ийн үйлдвэрлэл, удирдлага олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн юм.

Цаашид Монос Хүнс ХК нь Үйлдвэрлэл, менежментдээ ISO 22000:2005 болон олон улсын хүний нөөцийн ISO 30400 бүлэг стандартыг нэвтрүүлэхээр төслийн багийг байгуулаад байна.



ШИЛДЭГ САВ БАГЛАА БООДОЛТОЙ БҮТЭЭГДЭХҮҮН ЭНХЖИН



Энхжин эрүүл мэндийн цуврал цай бүтээгдэхүүн нь "Улаанбаатар Түншлэл 2019" олон улсын намрын үзэсгэлэн жармагаас "ШИЛДЭГ САВ БАГЛАА БООДОЛТОЙ БҮТЭЭГДЭХҮҮН"-ээр шалгарлаа.

ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН BERRYVIT



Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн уриан дор зохион байгуулагдсан "Намрын ногоон өдрүүд 2019" үзэсгэлэн худалдааны "ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН"-ээр Монос Хүнс ХК-ийн үйлдвэрлэн гаргадаг BERRYVIT брэндийн ааруултай үрэл шалгарлаа.

БНСУ-ЫН GENOSS, DENTIUM КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД БОЛОН DANKOOK ИХ СУРГУУЛИЙН СУДЛААЧИД МОНОС ГРУПП-Д АЙЛЧЛАЛ ХИЙЛЭЭ



БНСУ-ын Genoss, Dentium компанийн болон Dankook Их Сургуулийн төлөөлөгчид Монос Групп-тэй хоёр талт хамтын ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлж буй хамтарсан төслүүд болон судалгаа шинжилгээг шат ахиулах талаар хоёр өдрийн албан уулзалт хийлээ.

Монос Групп нь Монгол улсын эмийн ургамлын судалгаа, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх чиглэлээр Dankook Их Сургуулийн судалгааны төвтэй 2017 онд гэрээ байгуулсан. Үүний үр дүнд ясны сийрэгжилтийг эмчлэх шинэ эм бэлдмэл зохион бүтээсэн юм.

Цаашид БНСУ-ын Dankook их сургууль нь Монос Хүнс ХК, Монос Фарм ХХК-ийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт дээр хамтран ажиллахаар боллоо. Бид дэлхийн эрүүл мэндийн хүнсний зах зээлд тэргүүлж буй чиг хандлага, Монголчуудын биологийн онцлог, өвчлөлийн түүхийг харгалзан үзэж, олон жилийн туршлага судалгаан дээр үндэслэн илүү олон, гайхалтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх болно.

МОНОС ХҮНС ХК-ИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН УС УНДАА ТӨСЛИЙН ЯВЦ

Монос Хүнс компани нь нийт хувьцааныхаа 30 хувь буюу нийт 8,6 тэрбумын төгрөгийн 122 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгосон бөгөөд татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө олон улсын GMP, ISO-9001:2015, HACCP зэрэг стандартын шаардлагыг хангасан, орчин үеийн дэвшилтэд технологи бүхий Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулах юм. Эдүгээ тус үйлдвэрийн бүтээн байгуулалт дуусах шатандаа орж байгаа бөгөөд 11 сард бүрэн ашиглалтад орох юм.

Үйлдвэр бүрэн ашиглалтад орсноор үйлдвэрлэлийн хүчин чадал одоогийнхоос 24 дахин нэмэгдэхээс гадна олон төрлийн бүтээгдэхүүн шинээр үйлдвэрлэж, Монголд төдийгүй олон улсад зах зээлээ тэлэхээр зорьж байна.



Найрлагын
шугам: **85%**



Савлах
Шугам: **90%**





Цэвэр
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

+21.4%

6.8 тэрбум₮

ЕБИТДА

+26.8%

1.4 тэрбум₮

Эрүүл мэндийн
Ус ундаа төсөл

90%

гүйцэтгэлтэй

Ажилтнуудын
Сэтгэл ханамжийн
төвшин 2019 онд:

4.4/5.0


2018 онд: 4.1

Санхүү байдлын хураангуй тайлан

Сая төгрөг	2018.09.30	2019.09.30
ХӨРӨНГӨ	15,318	22,220
Эргэлтийн хөрөнгө	3,750	10,651
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	107	763
Дансны авлага	1,047	1,522
Бусад авлага	57	1,505
Бараа материал	1,480	1,801
Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,058	5,059
Эргэлтийн бус хөрөнгө	11,568	11,569
Үндсэн хөрөнгө	7,578	8,083
Биет бус хөрөнгө	3,987	3,476
Хойшлогдсон татварын хөрөнгө	3	11
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	15,318	22,220
Өр төлбөр	5,959	4,842
Богино хугацаат өр төлбөр	2,061	1,508
Урт хугацаат өр төлбөр	3,898	3,334
Эздийн өмч	9,359	17,377
Өмч	1,623	2,318
Нэмж төлөгдсөн капитал		6,836
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,985	6,529
Хуримтлагдсан ашиг	750	1,694

Орлого үр дүнгийн хураангуй тайлан

Сая төгрөг	2018.09.30	2019.09.30
Цэвэр борлуулалтын орлого	5,596	6,796
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,094	3,772
Нийт ашиг	2,503	3,023
Үйл ажиллагааны зардал	1,847	2,483
Үйл ажиллагааны ашиг	655	540
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	-33	74
Татвар төлөхийн өмнөх ашиг	622	614
Татварын зардал	69	78
Татварын дараах ашиг	553	537
Хүү татвар элэгдлийн өмнөх ашиг	1,094	1,387
Үйл ажиллагааны ашгийн түвшин	12%	8%
Цэвэр ашгийн түвшин	10%	8%
Хүү татвар элэгдлийн өмнөх ашгийн түвшин	20%	23%



2019.05.20-ны
хаалтын ханш: **71.6₮**

2019.09.30-ны
хаалтын ханш: **59.9₮**

Хамгийн дээд
ханш: **72.0₮**

Хамгийн доод
ханш: **53.8₮**

Нийт
арилжаалагдсан
тоо ширхэг: **11.6 сая**

Нийт арилжааны
үнийн дүн: **792.3
Сая ₮**

2019.09.30-ны
байдлаарх
компанийн үнэлгээ: **24.5
Тэрбум ₮**

2019 оны III улирлын байдлаар Монгол хөрөнгийн бирж дээрх идэвхтэй арилжаалагдсан үнэт цаасны тоо ширхгээр 4 дүгээрт, үнийн дүнгээр 13 дугаарт жагссан байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- 2019-07-09 өдөр тус компанийн ТУЗ-д хараат бус гишүүнээр сонгогдсон Б.Гантулга, Б.Долгормаа, Ч.Чинзориг нар компанийн үйл ажиллагаа, үйлдвэрийн барилгатай болон Эрүүл мэнд ус ундаа төслийн хүрээнд баригдаж байгаа шинэ үйлдвэрийн барилгын явцтай танилцлаа.
- 2019-07-20 өдөр ТУЗ-ийн ээлжит хурал болж Монос хүнс ХК-ийн 3-р улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэн батлав. Хурлын үеэр ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурлын үеэр баримтлах “хурлын дэг”-ийг батлан цаашид мөрдөж ажиллахаар тогтов.
- 2019-07-29 өдөр ТУЗ-ийн дэргэдэх Стратеги, бизнес хөгжлийн хороо хуралдаж Компанийн ойрын 3 жилийн стратеги төлөвлөгөө, 2019 оны төсвийн тодотгол, Эрүүл мэндийн ус ундаа төслийн хүрээнд шинээр хөгжүүлж буй бүтээгдэхүүний хөгжүүлэлтийн явцтай танилцан, санал зөвлөмж өгөв
- 2019-08-23 өдөр ТУЗ-ийн ээлжит бус хурал хуралдаж Монос хүнс компанийн 2019 оны төсвийн тодотголыг хэлэлцэх батлав.



Чулууны ЧИНЗОРИГ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн,
Стратеги, бизнес хөгжлийн хорооны гишүүн
Тандем Глобал ложистик Монголиа ХХК,
Гүйцэтгэх захирал



Бөхбатын ДОЛГОРМАА

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга,
Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн
Голомт фاینэншил групп ХХК,
Санхүү хариуцсан дарга



Булганы ГАНТУЛГА

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны гишүүн
Стратеги, бизнес хөгжлийн хорооны гишүүн
Монголын Хувьцаат компаниудын холбоо,
Ерөнхийлөгч
Ард Лайф ХХК, Гүйцэтгэх захирал



Лувсангийн ХҮРЭЛБААТАР

ТУЗ-ийн дарга
Монос групп ХХК,
Ерөнхийлөгч



Хүрэлбаатарын АНАНД

ТУЗ-ийн ердийн гишүүн
Стратеги, бизнес хөгжлийн хорооны дарга
Монос групп ХХК,
Гүйцэтгэх захирал



Цэдэндамбын ЦЭЦЭГБАДАМ

ТУЗ-ийн ердийн гишүүн
Аудитын хорооны гишүүн
Монос групп ХХК,
Санхүү эрхэлсэн захирал



Хүрэлбаатарын СОЛОНГО

ТУЗ-ийн ердийн гишүүн
Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны
дарга
Монос Косметик ХХК,
ТУЗ-ийн дарга



Чимэддоржийн БАТТОГТОХ

ТУЗ-ийн ердийн гишүүн
Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их
Сургууль,
Тэнхмийн эрхлэгч



Агваандоржийн ОТГОНДАРЬ

ТУЗ-ийн ердийн гишүүн
Монос Хүнс ХК,
Гүйцэтгэх захирал

МОНОС
ХҮНС

БАЯРЛАЛАА

